



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/324

Өмнөдэлгэр сум

Газрын дуудлага худалдаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Монгол Улсын Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 09 дугаар сарын 02-ний өдрийн 74 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчдийн 2025 оны 05 дугаар сарын 06-ний өдрийн 05 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчдийн 2025 оны 08 дугаар сарын 13-ний өдрийн 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өмнөдэлгэр суманд явагдах дуудлага худалдааны зориулалт, анхны үнэ болон газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг хавсралтаар тогтоосугай.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсугай.

3.Дуудлага худалдааг зохих хууль, тогтоомж, журмын дагуу зохион байгууллахыг Газрын даамал /Ё.Мөнх-Өлзий /-д даалгасугай.



Р.ЭНХТӨР



сумын Засаг даргын 2025 оны
4-р дүгээр сарын 20-ны өдрийн
А/304 дугаар захирамжийн хавсралт

№	Багийн нэр	Газрын байршил	Газрын хэмжээ /м2/	Газрын зориулалт	Газар эзэмшүүлэх хугацаа /жил/-ээр	Анхны үнэ /төг/	Дэвчлэлийн үнэ /төг/	Оролцоогийг бүртгэх хугацаа	Дуудлага худалдаа эхлэх дуусах хугацаа	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар
1	Өмнөдэлгэр 6-р баг	Айраг	8000	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор	15	6400000	640000	2025 оны 11 сарын 28-наас 12 сарын 04-ний 15 цаг 00 минут хүртэл	2025 оны 12 сарын 05-ны 09 цаг 00 мин-аас 15 цаг 00 минут хүртэл	4730474



	Өмнөдэлгэр 6-р баг	Х.Дамба	40	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор	15	32000	3200	2025 оны 11 сарын 28-наас 12 сарын 04- ний 15 цаг 00 минут хүртэл	2025 оны 12 сарын 05-ны 09 цаг 00 мин-аас 15 цаг 00 минут хүртэл	4759148	
	Өмнөдэлгэр 6-р баг	Айраг	5000	Шатахуун түгээх газар, агуулах	15	4000000	400000	2025 оны 11 сарын 28-наас 12 сарын 04- ний 15 цаг 00 минут хүртэл	2025 оны 12 сарын 05-ны 09 цаг 00 мин-аас 15 цаг 00 минут хүртэл	4726792	
	Дүн		13040								